

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.9 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.5, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах шийдвэр гаргах төлбөрийн хэм хэмжээг тогтоох ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Д.Дамдинсүрэн

Гишүүд: -АИТХ-ын Хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн
- Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн зохицуулах
-АИТХ-ын ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга
-Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн Хуулийн зөвлөгөө мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Хоёр: Ажлын хэсэг нь Захиргааны ерөнхий хуулийн дагуу Сонсох ажиллагааны явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж, гарсан саналыг захиргааны шийдвэрт хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэж баримтжуулах, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журмын дагуу аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлуулахыг ажлыг хэсгийн ахлагч /Д.Дамдинсүрэн/-д даалгасугай.

ДАРГА

Ц.БАТБОЛД

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “д”, 19 дүгээр зүйлийн 19.1.4, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4, Хууль зүйн сайдын 2019 оны А/101 дүгээр тушаалын хавсралтын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Увс аймгийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа ажиллуулах үйл ажиллагааг хувийн хэвшил, аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлсүгэй.
2. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагааны төлбөрийн хэмжээг нэгдүгээр хавсралтаар, Тээврийн хэрэгслийг Улаангом сумын нутаг дэвсгэрт зөөж шилжүүлэх гудамж зам, хамрах хүрээ, үйлчлэх цагийн хязгаарыг хоёр дугаар хавсралтаар, түр саатуулах хашаа /байр/-ны үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тавигдах шаардлагыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тогтоолыг хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ч.Чимэд/-д даалгасугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын нарийн бичгийн үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дамдинсүрэн/-д даалгасугай.

ДАРГА

Ц.БАТБОЛД

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын 5 дугаар хуралдааны 2021 оны
..... дугаар тогтоолын нэг дүгээр хавсралт

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа
/байр/ ажиллуулах үйл ажиллагааны төлбөрийн хэмжээ

Нэг. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Төлбөрийн хэмжээ /хоногоор/
1	Мотоцикль	15,000 төгрөг
2	Суудлын автомашин, микроавтобус /жолоочоос гадна 8-с илүүгүй хүний суудалтай/, бүх жин нь 3500кг хэтрэхгүй автомашин	35,000 төгрөг
3	Бүх жин 5000кг хүртэлх ачааны, 40 хүртэлх хүний суудалтай автобус трактор	50,000 төгрөг
4	Хүнд даацын ачааны автомашин том оврын автобус, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл	90,000 төгрөг
5	Аймгийн төвөөс гадагш 100км тутамд 20,000 төгрөг нэмэлтээр тооцно.	

Хоёр. Түр саатуулах хашаа /байр/-ны төлбөрийн хэмжээ

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Төлбөрийн хэмжээ /хоногоор/
1	Мотоцикль	2500 төгрөг
2	Суудлын автомашин, микроавтобус /жолоочоос гадна 8-с илүүгүй хүний суудалтай/, бүх жин нь 3500кг хэтрэхгүй автомашин	5000 төгрөг
3	Бүх жин 5000кг хүртэлх ачааны, 40 хүртэлх хүний суудалтай автобус трактор	7000 төгрөг
4	Хүнд даацын ачааны автомашин том оврын автобус, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл	10,000 төгрөг
5	Зам тээврийн осол зөрчлийн улмаас саатуулагдсан тээврийн хэрэгсэл	25,000 төгрөг / 1-60 хоногийн дотор /
6	Дулаан грашд байршуулах	15,000 төгрөг

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын 5 дугаар хуралдааны 2021 оны
..... дугаар тогтоолын хоёр дугаар хавсралт

Тээврийн хэрэгслийг Улаангом сумын нутаг дэвсгэрт зөөж
шилжүүлэх гудамж зам, хамрах хүрээ, үйлчлэх цаг

№	Түр зогсохыг хориглох гудамж, зам, хамрах хүрээ	Үйлчлэх цаг
1	Улаангом сумын төвийн Х.Баянмөнхийн гудамжнаас арын дөрвөн замын уулзвар хүртэл	07:00-20:00 минут
2	Худалдааны гудамж Шунхлай шатахуун түгээх станцын хажуугийн уулзвараас ЕБ-ын 3 дугаар сургуулийн баруун уулзвар хүртэл	07:00-20:00 минут
3	Улаангом сумын 3-р багийн нутаг дэвсгэрт орон сууцны хорооллын дундах авто замуудад	07:00-20:00 минут

.....оОо.....

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын 5 дугаар хуралдааны 2021 оны
..... дугаар тогтоолын гурав дугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛЭХ, ТҮР
СААТУУЛАХ ХАШАА /БАЙР/ АЖИЛЛУУЛАХ БАЙГУУЛЛАГАД
ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

1. Түр саатуулах хашаа /байр/-ны тус бүрийн зогсоолын /ил болон битүү зогсоолын/
нийт талбайн хэмжээ 1000 м²-аас багагүй байх.
2. Дулаан гражтай байх ба дулаан гражд 15, ил зогсоолд 30 авто тээврийн хэрэгсэл
багтахаар зохицуулах
3. Гэрэлтүүлэг болон камерийн системээр бүрэн хангагдсан байх.
4. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх чирэгч автомашины жолооч мэргэшсэн
жолооч байх.
5. Байнгын харуул хамгаалалттай байх.
6. Шаардлагатай үед 24 цагаар ажиллахад хүн хүч, техник тоног төхөөрөмжийн
бололцоотой байх.
7. Тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ үйл ажиллагаа
эрхлэгч байгууллага нь авто засвар болон сэлбэг худалдааны үйл ажиллагаа
эрхлэхийг хориглоно.
8. Хууль эрх зүйн аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтантай байх
9. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх үед болон түр саатуулах хашаа, гражид
байх үеийн аливаа эрсдэлээс хамгаалах даатгалд хамрагдсан байх.
10. Хууль зүйн сайдын 2019 оны А/101 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар
батлагдсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам “–ын 9 дэх
хэсгийг мөрдлөг болгон ажиллах.

.....оОо.....

